

ЗУУЧЛАЛААР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ – Таны ажил олгогч нь хөдөлмөр зуучлалын агентлаг (agentur) бөгөөд танд ажил зуучилна, өөрөөр хэлбэл та түр хугацаагаар өөр ажил олгогч дээр томигдож ажиллана.

АНХААР! ТА ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГ (эсвэл DRČ) АЖИЛ ОЛГОГЧТОЙ БИШ ХӨДӨЛМӨР ЗУУЧЛАЛЫН АГЕНТЛАГТАЙ БАЙГУУЛНА.

ГЭРЭЭ НЬ ҮРГЭЛЖ БИЧГЭЭР БАЙХ ЁСТОЙ.

Хөдөлмөр зуучлалын агентлаг нь хөдөлмөр зуучлалын агентлагуудын жагсаалтад багтах ёстой. Бүртгэлийг Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс (Úřad práce) гаргадаг.

Агентлагийн жагсаалтыг эндээс шалгаж боломжтой:
<https://www.uradprace.cz/web/cz/agentury-prace>.

Хөдөлмөр зуучлалын газраас өөр ажил олгогч дээр ажиллах бол хөдөлмөрийн агентлагтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнээс гадна та ажилтны хувьд өөр ажил олгогч дээр ажиллахыг зөвшөөрч буй *бичгээр зааварчилсан* – хөдөлмөрийн гэрээтэй байх шаардлагатай.

Гэрээ нь тодорхой байх ёстой:

- ажил олгогч,
- ажиллах газар,
- таны хэр удаан ажиллах,
- ажлын байрны нөхцөл,
- цалин,
- таны дарга эсвэл танд үүрэг даалгавар өгч мөн гүйцэтгэсэн ажлыг шалгаж болох хүн,
- ажиллаж дуусах хугацаа (огноо).

Та мэдэх үү:

- Хөдөлмөр зуучлалын агентлаг болон таны томилогдсон ажил олгогч нар аль аль нь таныг бусад ажилчдын адил ажиллах нөхцөлөөр хангах үүрэгтэй.
- Хөдөлмөр зуучлагч агентлагийн ажилтан нэгэн зэрэг томилогдсон компанид үндэс ажилтан байж болохгүй.
- Хөдөлмөр зуучлагч агентлагийн ажилтан нэг томилогдсон ажил олгогч дээрээ мөн нэг ажлын байранд дараалан хуанлийн 12 сар л ажиллах боломжтой.
 - Онцгой тохиолдолд, ажилтан хөдөлмөр зуучлагч агентлагаас ажиллах хүсэлт гаргах эсвэл
 - ажилчин жирэмсний чөлөө эсвэл эцэг эх болсны амралт авч байгаа тухайн хугацаанд ажил гүйцэтгэх бол.
- Таны хөдөлмөрийн харилцааг томилогдсон ажил олгогч биш хөдөлмөр зуучлагч агентлаг цуцалж болно.

АНХААР !

- **АЖЛЫН КАРТААР БНЧУ-Д ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛТТЭЙ ГАДААДЫН ИРГЭД, ХӨДӨЛМӨР ЗУУЧЛАЛЫН АГЕНТЛАГТ ЧЕХ УЛСАД ИРСНИЙ ДАРАА Л АЖИЛЛАХ БОЛОМЖТОЙ – ГЭХДЭЭ ЗӨВХӨН БНЧУ-Д ИРЭХИЙН ӨМНӨ ЗӨВШӨӨРӨГДСӨН ТОХИОЛДОЛД БОЛОМЖТОЙ.**
- **ХЭРВЭЭ ТА АЖИЛЛАА СОЛИХ БОЛ ДАХИЖ ХӨДӨЛМӨР ЗУУЧЛАГЧ АГЕНТЛАГТ АЖИЛЛАЖ БОЛОХГҮЙ.**